



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 1/51

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.7, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 2/01 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “Бүтээлч Өвөрхангай-2020” хөтөлбөрийн 4.1.5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Хятад улсын Техник, технологийн мэргэжил дээшлүүлэх институттэй хамтран 2019 оны 8 дугаар сарын 7-29-ний өдрүүдэд Өвөрмонголын өөртөө засах орны Хөх хотод зохион байгуулагдах “Хүнс, хөдөө аж ахуйн салбарын мэргэжилтнүүдийг чадавхижуулах” сургалтад Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэр, худалдаа, үйлчилгээний бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэнг хамруулахад шаардагдах 1000000 (нэг сая) төгрөгийн зардлыг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтад тусгагдсан 1000000 (нэг сая) төгрөгийн зардлыг дотоод албан томилолтын зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч (О.Цэрэнчимэд)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ц.ГАНБОЛД

012100161

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
даргын 2019 оны 04 дугаар сарын 29 -ны
өдрийн 1/57 дугаар тушаалын хавсралт



ӨВӨРМОНГОЛЫН ӨӨРТӨӨ ЗАСАХ ОРНЫ ХӨХ ХОТОД
ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ СУРГАЛТАД ШААРДАГДАХ
ЗАРДЛЫН ЖАГСААЛТ

№	Зардлын нэр	Зардлын дүн төгрөгөөр
1	Сургалтын урилга	200000
2	Хөх хот хүртэл ирэх, буцах замын зардал /вагоноор/	542000
3	Бусад хэрэглээний зардал	258000
	Нийт дүн	1000000

-oOo-